

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 67.060, 67.160.20

Үр тарианы тэжээллэг ундаа “БОЗА”. Техникийн ерөнхий шаардлага	MNS ... : 2023
"BOZA" nutritious cereal beverage. General technical requirements	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны .. дугаар сарын ..-ны өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь төрөл бүрийн үр тариагаар “БОЗА” нэрийн ундаа үйлдвэрлэх, савлах, шошголох, хадгалах, тээвэрлэх, шалгаж хүлээн авах шаардлагыг тогтооно.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад олон улсын болон Монгол улсын дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд сүүлчийн албан ёсны эх хэвлэлээс эш татаж хэрэглэнэ. Үүнд:

MNS CAC RCP 1, *Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (Олон улсын зөвлөмж),*

MNS 3810:2020, *Хүнсний арвай. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 0097:2010, *Хүнсний буудай. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 2025:82, *Хүнсний хөх тариа. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 254-1:1987, *Тариа хүлээн авах журам, Дээж авах журам*

MNS 0900, *Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ,*

MNS 6308:2012, *Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ*

MNS CAC 193, *Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт,*

MNS 4504, *Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх хэмжээ,*

MNS 5868, *Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ,*

MNS 5343, *Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага,*

MNS 6308, *Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ,*

MNS 6361, *Хүнс, малын тэжээл дэх микотоксины үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ,*

MNS 5547, *Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол. Техникийн ерөнхий шаардлага,*

MNS 5684, *Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ,*

MNS 6648, *Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтонд тавих шаардлага.*

3 Ангилал

3.1 Үндсэн түүхий эдээр нь:

3.1.1 Энгийн боза

3.1.2 Баяжуулсан боза

3.1.2.1 Баяжуулсан түүхий эдээр нь:

- Зөгийн балтай боза
- Жимстэй боза
- Хивэгтэй боза
- Самартай боза гэж тус тус ангилна

4 Нэр томьёо, тодорхойлолт

4.1

энгийн "Сонгодог" боза

буудай, арвай, хөх тарианы бүхэл үрийг устай хамт даралттай, зориулалтын тогоонд чанаж цийдмэгжүүлэн, хивэгийг хэсэгчлэн зайлуулж бэлтгэсэн ундаа

4.2

зөгийн балтай Боза

энгийн Боза ундааг зөгийн балаар баяжуулсан нэр төрөл

4.3

жимстэй Боза

энгийн Боза ундааг жимс, жимсгэнийн шүүс, жүүс, чанамалаар баяжуулсан нэр төрөл

4.4

хивэгтэй Боза

энгийн Боза ундааг үр тарианы хивгээр баяжуулсан нэр төрөл

4.5

самартай Боза

энгийн Боза ундааг төрөл бүрийн самараар баяжуулсан нэр төрөл

5 Техникийн шаардлага

5.1 Үр тарианы Боза ундааг "MNS CAC RCP 1, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж)" стандартын шаардлага хангасан үйлдвэрт зохих журмын дагуу баталгаажсан жор, технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэнэ.

5.3 Үр тарианы Боза ундааны чанар нь мэдрэхүйн үнэлгээгээр 1, физик-химийн үзүүлэлтээр 2, эрүүл зүйн шалгуур үзүүлэлтээр 3, аюулгүй байдлын үзүүлэлтээр 4 дүгээр хүснэгтэд заасан шаардлагыг тус тус хангасан байна.

1-р хүснэгт - Үр тарианы Боза ундааны мэдрэхүйн үзүүлэлт, шаардлага

Үзүүлэлт	Шаардлага, шинж чанар /нэр төрлөөр/				
	Сонгодог	Зөгийн балтай	Жимстэй	Хивэгтэй	Самартай
Савлалт	Зориулалтын саванд зохих хэмжээгээр савлаж, таглаж битүүмжилсэн, шошгонд үйлдвэрлэсэн өдөр, сарыг тэмдэглэсэн байна.				
Гадаад байдал	Сав нь цоорч гэмтээгүй, битүүмжлэл алдагдаагүй, шошгоны мэдээлэл тод, гаргацтай байна.				
Өнгө	Жигд цайвар шаргал өнгөтэй		Нэмсэн жимсний өнгөөр өнгө нь хувирсан	Хивэгний ширхэгийн хүрэн толбо бүхий бор шаргал өнгөтэй	Самрын идээний шаргал буюу бор толбо бүхий бор шаргал өнгөтэй
Үнэр	Чанасан үр тарианы сул үнэртэй. Гаднын үнэргүй	Чанасан үр тарианы тааламжтай үнэртэй. Гадны үнэргүй	Нэмсэн жимсний үнэр мэдрэгдсэн. Гаднын үнэргүй	Чанасан үр тарианы үнэр илүү мэдрэгдсэн. Гаднын үнэргүй	Самар болон хуурсан тарианы хоршмол үнэртэй. Гаднын үнэргүй.
Амт	Чанасан үр тарианы амттай. Гаднын амтгүй	Сул чихэрлэг амттай. Гаднын амтгүй	Жимсний амт мэдрэгдсэн. Гаднын амтгүй	Чанасан үр тарианы амт илүү мэдрэгдсэн. Гаднын амтгүй	Чанасан үр тариа болон самрын амттай. Гаднын амтгүй
Биет байдал	Жигд өтгөвтөр, урсамхай масс	Жигд үл мэдэг шингэвтэр урсамхай масс	Жигд өтгөвтөр, урсамхай масс	Хивэгний жижиг ширхэг бүхий өтгөвтөр, урсамхай масс	Самрын жижиг ширхэг бүхий өтгөвтөр, урсамхай масс

2-р хүснэгт - Үр тарианы Боза ундааны физик-химийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Байвал зохих хэмжээ				
		Сонгодог	Зөгийн балтай	Жимстэй	Хивэгтэй	Самартай
1	Хуурай бодис, %, багагүй	4,0	6,5	10,0	4,0	8,0
2	Хүчиллэг, %, ихгүй	1,0	1,0	1,0	1,0	1,0
3	Чихэрлэг, %, багагүй	-	6,0	8,0	-	-
4	Тослог, ХБШ %, багагүй	-	-	-	-	1,0
5	Үнслэг, %, ихгүй	1,0	1,0	1,0	1,5	1,5
6	Сүүний хүчлийн бактери	3 x 10 ⁴ – 6 x 10 ⁷				

3-р хүснэгт - Үр тарианы Боза ундааны эрүүл зүйн үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Хөгц мөөгөнцөр	MNS 6308 стандартын шаардлагад нийцсэн байна.
2	Колиформ	Илрэх ёсгүй
3	Bacillus cereus	Илрэх ёсгүй

4	Salmonella	Илрэх ёсгүй
---	------------	-------------

4-р хүснэгт–Үр тарианы Боза ундааны аюулгүй байдлын үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Зөвшөөрөх хэмжээ
1	Хүнд металлын агууламж	MNS 4504 стандартын шаардлагад нийцсэн байна.
2	Цацраг идэвхт бодисын үлдэгдэл	MNS CAC 193 стандартын шаардлагад нийцсэн байна.
3	Пестицидийн үлдэгдэл	MNS 5868 стандартын шаардлагад нийцсэн байна.
4	Афлатоксин	Илрэх ёсгүй

6 Шалгаж хүлээн авах

Үр тарианы Боза ундааг дараах стандартын дагуу шалгаж хүлээн авна.
MNS 5321, Төрөл бүрийн ундаа. Шинжлэх арга, /хүчиллэг тодорхойлох/
MNS 0343, Чихэр боовон бүтээгдэхүүн. Хуурай бодис тодорхойлох арга,
MNS 0343, Чихэр боовон бүтээгдэхүүн. Тослог тодорхойлох арга,
MNS 0344, Чихэр боовон бүтээгдэхүүн. Чихэрлэг тодорхойлох арга,
MNS 2151, Сүү, цагаан идээ. Үнс /эрдэс бодис/ тодорхойлох арга,
MNS 4340, Хүнсний бүтээгдэхүүнд төмрийн агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга,
MNS 4496, Хүнсний бүтээгдэхүүнд хар тугалгын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга,
MNS 4497, Хүнсний бүтээгдэхүүнд цайрын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга,
MNS 4498, Хүнсний бүтээгдэхүүнд зэсийн агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга,
MNS 4499, Хүнсний бүтээгдэхүүнд кадмийн агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга,
MNS 4516, Хүнсний бүтээгдэхүүнд цагаан тугалгын агуулгыг тодорхойлох спектрометрийн арга,
MNS 4832, Хүнсний бүтээгдэхүүнд фосфор органик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга,
MNS 4833, Хүнсний бүтээгдэхүүнд хлор органик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга,
MNS 5069, Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс зэрэг ургамлын гаралтай бүтээгдэхүүнд цацраг идэвхт элемент тодорхойлох гамма спектрометрийн арга,
MNS 5549, Хүнсний бүтээгдэхүүнд афлатоксин В1, В2, G1, G2-ийн агууламжийг тодорхойлох нимгэн үеийн хроматографийн арга (хэвшмэл арга),
MNS 6052, Үр тариа, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд нян, хөгц мөөгөнцөр тодорхойлох “Rida count”-ийн арга,
MNS ISO 7954, 25 градуст ургасан хөгц, мөөг, хөрөнгөнцөрийн колони тоолох арга,
MNS ISO 6579-1, Хүнсний микробиологи. Salmonella илрүүлэх, тоолох, серологийн шинжээр ялгах ерөнхий арга. 1-р хэсэг: Salmonella spp. илрүүлэх арга.
MNS ISO 4831, Колиформын тоог тоолох. Колони тоолох арга,
MNS ISO 7932, Хүнсний бүтээгдэхүүн болон малын тэжээлийн микробиологи. Таамаглаж буй Bacillus cereus-ийг тоолох ерөнхий арга. 30°C-т колони тоолох арга

7 Савлалт, хаяглалт

7.1 Үр тарианы Боза ундааг “MNS 5547, Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол. Техникийн ерөнхий шаардлага”, “MNS 5684, Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ” стандартын шаардлага хангасан материалтай зориулалтын таглаа бүхий уут, саванд дор дурдсан хэмжээгээр савлаж, таглаж битүүмжилнэ. Үүнд:

- мөнгөлөг дотортой, таглаатай зориулалтын нийлэг саванд 180 г, 250 г, 300 г
- таглаа бүхий, тунгалаг нийлэг саванд 2,5 кг, 5,0 кг, 10 кг–аар тус тус савлана.

7.2 Савласан бүтээгдэхүүний цэвэр жин шошгонд дурьдсан хэмжээнээс 5 дугаар хүснэгтэд заасан хувиар хэлбэлзэж болно.

5-р хүснэгт - Нэгж савлагаатай бүтээгдэхүүний жингийн хэлбэлзэл

Д/д	Савласан бүтээгдэхүүний цэвэр жин	Хэлбэлзэл, хувиар ихгүй /бага тал руугаа/
1	180 г	-4,5 %
2	250 г	
3	300 г	
4	2,5 кг	-1,5 %
5	5,0 кг	
6	10,0 кг	

7.3 Бүтээгдэхүүнийг савлах уут, сав болон тэдгээрийн таглаа нь механик гэмтэлгүй, цэвэр, хуурай, гаднын үнэргүй байна.

7.4 Савласан бүтээгдэхүүн нь “MNS 6648, Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” стандартын шаардлага хангасан шошготой байна.

7.5 7.1-д заасны дагуу савласан ундааг зориулалтын сагс, тэвш болон картон хайрцагт багтаамжаар нь, шахалгүйгээр багцлан савлана.

8 Хадгалалт, тээвэрлэлт

8.1 Багцлан савласан бүтээгдэхүүнийг (0-4) °C температуртай зориулалтын хөргүүрт, тавиур тавцанд эгнүүлэн өрж хадгална.

8.2 Үр тарианы Боза ундааны хадгалалтын хугацаа нь нэр төрлөөс хамаарч үйлдвэрлэсэн өдрөөс эхлэн дор дурдсанаас илүүгүй байна.

- Энгийн “Сонгодог” болон “Хивэгтэй”, “Самартай” боза - 7 хоног
- “Зөгийн балтай”, “Жимстэй” боза - 5 хоног

8.3 Багцлан савласан бүтээгдэхүүнийг зориулалтын хөргүүр бүхий тээврийн хэрэгслээр “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим, MNS CAS RCP 1 (Олон улсын зөвлөмж)”, “Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих

ерөнхий шаардлага MNS 5343” стандартын дагуу, (0-4) °C температуртай нөхцөлд тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.

Ном зүй

TS 9778, ICS 67.060 БОЗА (Турк улсын стандарт)

САНАЛ АВАХ ТӨСӨЛ